



## УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн ИТХ-ын захиалга, ҮАГ-ын харьяа Увс аймгийн аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.



**Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ зорилтот бүлэгт чиглэгдэж үр нөлөөтэй зарцуулагдсан байна.**

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний

2014, 2015 оны үр дүн

2016 оны 07 сар

УВААГ-2016/03-ГА

**Товчилсон үгийн тайлал:**

ОНОТХҮ – Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

## **АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ**

### **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх**

Аймгийн ИТХ-ын захиалга, Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### **Аудитын зорилт**

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний эх үүсвэрийн зарцуулалтын байдалд үнэлэлт дүгнэлт гарган, үр дүнг дээшлүүлэх талаар санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитыг дараах зорилтын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хууль, тогтоомж заавар журмын дагуу явагдаж байгаа эсэх
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үр нөлөөтэй зарцуулагдсан эсэх

### **Хамарсан хүрээ**

Аудитад Увс аймгийн Халамж үйлчилгээний хэлтсийн Халамжийн сангийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 2014, 2015 онд зарцуулсан эх үүсвэрийг хамрууллаа.

### **Арга зүй**

Аудитыг гүйцэтгэхэд ТХШС, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, ОНОТХҮ-нд хамрагдсан байгууллага, иргэдийн үйл ажиллагааг газар дээр үзэж танилцах, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

Нийцлийн аудитыг аймгийн Аудитын газрын ахлах аудитор С.Алтанхундага, ахлах шинжээч М.Батсуурь, аудитор Т.Намжил, С.Батсайхан, шинжээч Л.Бат-Очир, Я.Зунгарав нар хийж гүйцэтгэлээ.

## Ерөнхий мэдээлэл

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний эх үүсвэрийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 18-р зүйлд тодорхойлсон арга хэмжээнд зарцуулж байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хуульд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

18.1-д Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байхаар заасан байна.

- 18.1.1-д Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах
- 18.1.2-д Зөвлөгөө өгөх
- 18.1.3-д Сэргээн засах үйлчилгээнд хамруулах
- 18.1.4-д Түр байрлуулан асрамжлах
- 18.1.5-д Өдрийн үйлчилгээнд хамруулах
- 18.1.6-д Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах
- 18.1.7-д Иргэн түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх
- 18.1.8-д Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах
- 18.1.9-д Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах субъектыг хуульд дараах байдлаар тодорхойлжээ

18.2-д Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд дараах өрх, иргэн хамрагдахаар заасан байна.

- 18.2.1-д Ахмад настан
- 18.2.2-д Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- 18.2.3-д Хүнд нөхцөлд байгаа хүүхэд
- 18.2.3-д Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд /Энэ заалтыг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулахаар заасан бөгөөд үүнийг 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/
- 18.2.4-д Хүчирхийлэлд өртсөн иргэн
- 18.2.5-д Хорих ангиас суллагдсан иргэн
- 18.2.6-д Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн
- 18.2.7-д Эдгэшгүй хүнд өвчтэй хүн
- 18.2.8-д Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн
- 8.2.9-д Шилжин суурьшсан энэ хуулийн 3.1.2-т заасан “Өрхийн гишүүн-иргэн, иргэн”
- 18.2.10-д Өрх толгойлсон эх /эцэг/
- 18.2.11-д Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх”

**Бүлэг1: Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ  
хууль, журмын дагуу явагдаж байна**

**1.1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хөрөнгийг  
хууль журмын дагуу зарцуулсан байна.**

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.3.-д “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тооцож нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу сумдын Амьжиргааг дэмжих зөвлөлөөс дэмжигдсэн төслүүдийг Нийгмийн халамж үйлчилгээний газарт хүргүүлэн ажилласан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 27-д заасны дагуу нийгмийн ажилтан 1, төрийн байгууллагын төлөөлөл 2, иргэний төлөөлөл 2, төрийн бус байгууллагын төлөөлөл 2, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийг сумдын Засаг даргын санал болгосноор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулжээ. Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл нь нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх талаар шийдвэр гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэг хүлээн үйл ажиллагаагаа явуулж байна.

Увс аймгийн хэмжээнд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний эх үүсвэрээс 2014 онд 18 суманд 53 төслөөр 119 иргэнд 40.7 сая, 5 аж ахуйн нэгжид 54.3 сая, 2015 онд 9 суманд 24 төслөөр 42 иргэнд 19.3 сая, 7 аж ахуйн нэгжид 20.7 сая, нийт 135.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Тухайн үйлчилгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцахад төслийг зориулалтын дагуу зарцуулжээ.

Сумдын Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийн шийдвэрээр 2014, 2015 онд дараах байдлаар ОНОТХҮ-ний санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний  
2014, 2015 оны үр дүн

**Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагсадын  
аж ахуйн нэгжийн судалгаа**

| № | ААН,ТББ-ийн нэр       | Гэрээлэн гүйцэтгэж байгаа<br>үйлчилгээний төрөл                                                                    | Санхүүжилтийн хэмжээ /төгрөг/ |            |            |
|---|-----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|------------|------------|
|   |                       |                                                                                                                    | 2014 он                       | 2015 он    | Нийт       |
| 1 | Тэнгэрлэг тус ХХК     | Уламжлалт аргаар сэргээн засах                                                                                     | 29,053,000                    | 7,600,000  | 36,653,000 |
| 2 | Тосон бөөрөг ТББ      | Уламжлалт аргаар сэргээн засах                                                                                     | 7,894,500                     | 4,000,000  | 11,894,500 |
| 3 | Төгс ачлал ХХК        | Орчин үеийн тоног төхөөрөмжөөр<br>сэргээн засах                                                                    | 11,201,000                    | 6,000,000  | 17,201,000 |
| 4 | Улаан загалмайн хороо | Өдрийн үйлчилгээ                                                                                                   | 3,210,000                     | 900,000    | 4,110,000  |
| 5 | Тэмүүлэл Увс БХДТ     | Амьдралын итгэл үнэмшил олгох,<br>бие даан амьдрах<br>чадвар,хөдөлмөрийн дадлага<br>олгох сургалт зохион байгуулах | 2,930,533                     | 600,000    | 3,530,533  |
| 6 | Сайн тус төв ТББ      |                                                                                                                    |                               | 720,000    | 720,000    |
| 7 | МХҮХолбоо             |                                                                                                                    |                               | 920,000    | 920,000    |
|   | Дүн                   |                                                                                                                    | 54,289,033                    | 20,740,000 | 75,029,033 |

**Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 2014, 2015 онд  
хамрагдсан төслийн санхүүжилтийн судалгаа**

| №                     | Сумын нэр                        | Төслийн тоо | Дэмжигдсэн<br>санхүүжилт |
|-----------------------|----------------------------------|-------------|--------------------------|
| <b>2014 оны төсөл</b> |                                  |             |                          |
| 1                     | Баруунтуруун/ядуурлаас гарах/    | 1           | 1,500,000                |
| 2                     | Бөхмөрөн/ядуурлаас гарах/        | 2           | 1,500,000                |
| 3                     | Давст/ядуурлаас гарах/           | 1           | 1,500,000                |
| 4                     | Зүүнговь сум /ядуурлаас гарах/   | 1           | 800,000                  |
| 5                     | Зүүнхангай сум /ядуурлаас гарах/ | 1           | 700,000                  |
| 6                     | Малчин/ядуурлаас гарах/          | 1           | 1,200,000                |
| 7                     | Наранбулаг                       | 1           | 1,000,000                |
| 8                     | Өлгий                            | 1           | 800,000                  |
| 9                     | Өмнөговь/ядуурлаас гарах/        | 1           | 800,000                  |
| 10                    | Өндөрхангай/ядуурлаас гарах/     | 1           | 800,000                  |
| 11                    | Сагил/ядуурлаас гарах/           | 1           | 600,000                  |
| 12                    | Тариалан/ядуурлаас гарах/        | 1           | 800,000                  |
| 13                    | Түргэн/ядуурлаас гарах/          | 2           | 1,000,000                |
| 14                    | Тэс/ядуурлаас гарах/             | 2           | 1,200,000                |
| 15                    | Ховд/ядуурлаас гарах/            | 1           | 800,000                  |
| 16                    | Хяргас                           | 1           | 800,000                  |
| 17                    | Цагаанхайрхан/ядуурлаас гарах    | 1           | 800,000                  |
| 18                    | Улаангом                         | 33          | 24,100,000               |
|                       | Дүн                              | 53          | 40,700,000               |
| <b>2015 оны төсөл</b> |                                  |             |                          |
| 1                     | Давст /ядуурлаас/                | 1           | 1,000,000                |
| 2                     | Завхан                           | 1           | 800,000                  |
| 3                     | Тариалан /ядуурлаас/             | 1           | 1,000,000                |

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний  
2014, 2015 оны үр дүн

|   |                       |    |            |
|---|-----------------------|----|------------|
| 4 | Түргэн сум/ядуурлаас/ | 1  | 800,000    |
| 5 | Сагил /ядуурлаас/     | 1  | 800,000    |
| 6 | Малчин/ядуурлаас      | 1  | 800,000    |
| 7 | Наранбулаг            | 1  | 800,000    |
| 8 | Хяргас                | 1  | 600,000    |
| 9 | Улаангом сум          | 16 | 12,660,000 |
|   | Дүн                   | 24 | 19,260,000 |
|   | Нийт дүн              | 77 | 59,960,000 |

**1.2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах зорилтот бүлгийн өрх иргэдийг сонгохдоо сум бүр амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн байна.**

ОНОТХҮ-ний эх үүсвэрээс санхүүжихээр 2014 онд 86, 2015 онд 49, нийт 135 төсөл ирснээс Амьжиргааг дэмжих зөвлөл хэлэлцэж 2014 онд 58, 2015 онд 31, нийт 89 төслийг дэмжин Нийгмийн халамж үйлчилгээний газарт хүргүүлснийг санхүүжүүлжээ. 2014, 2015 онуудад ОНОТХҮ-д нийт 77 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан байна. Үүнд:

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 2014, 2015 онд  
хамрагдсан төслийн судалгаа

| Д/д | Төслийн чиглэл        | 2014 | 2015 | Нийт |
|-----|-----------------------|------|------|------|
| 1   | Үйлдвэрлэл            | 3    | 1    | 3    |
| 2   | Үйлчилгээ             | 4    |      | 4    |
| 3   | мал аж ахуй           | 3    | 1    | 4    |
| 4   | мужаан, дархан        | 4    | 4    | 8    |
| 5   | Газар тариалан        | 9    | 4    | 13   |
| 6   | эсгий, сур, шир урлал | 10   | 5    | 15   |
| 7   | авто засвар           | 1    |      | 1    |
| 8   | хатуу, зөөлөн оёдол   | 19   | 9    | 28   |
|     | Дүн                   | 53   | 24   | 77   |

**1.3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хөрөнгийн зарцуулалтын баримтын бүрдэл хэвийн байна.**

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн иргэдийн болон үйлчилгээ үзүүлэхээр шалгарсан хуулийн этгээдийн холбогдох баримтын бүрдлийг журмын дагуу бүрдүүлж санхүүжүүлсэн байна. Тухайн хөрөнгийн зарцуулалтын баримтын бүрдэл хангалттай байна.

**Дүгнэлт :**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хөрөнгийн зарцуулалт хэвийн явагдаж байна.

**Бүлэг 2: Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хэвийн явагдаж байна**

**2.1 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хэвийн явагдаж байна.**

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийн төслүүдийг аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс жил бүр сонгон шалгаруулалт хийж шалгарсан аж ахуйн нэгжийн материалыг Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэн зөвшөөрөл олгодог байна.

Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжид 2014 онд 54.3 сая, 2015 онд 20.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсээс 2016 оны 5 дугаар сарын 30-нд сонгон шалгаруулалтыг хийж 6 аж ахуйн нэгжийн материалыг Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлжээ. Сонгон шалгаруулалт хийж, зөвшөөрөл ирээгүй байгаа учир санхүүжилт олгогдоогүй байна.

2014, 2015 онд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, ажлын байрны зураг авалт хийсэн бөгөөд үйл ажиллагаа хэвийн явагдсан байна. Хамрагдсан иргэдтэй аудитын явцад түүврийн аргаар уулзсан болно.



Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрх иргэдийг хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зорилгоор 2014 онд 18 сумын 53 зорилтот бүлгийн 122 өрхийн 501 иргэнийг хамруулан 40.7 сая, 2015 онд 9 сумын 24 зорилтот бүлгийн 49 өрхийн 220 иргэнийг хамруулан 19.3 сая төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд харагдаж төслийн санхүүжилт авсан иргэдийн хувьд түүврийн арга ашиглан уулзалт, ажлын байрны зураг

авалт хийхэд сэтгэл ханамжийн хувьд өрхийн амьжиргааг дээшлүүлэх тал дээр бидний амьдралд ахиц болж байна. Гэхдээ зарим иргэд томоохон үйлдвэрлэл явуулахад шаарддагдах эх үүсвэрийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч олгогдож байгаа санхүүжилтийн хэмжээг 2.0 сая хүртэл болговол тоног төхөөрөмж, шаардлагатай түүхий эдээ авах боломж бүрдэх боломжтой байна гэсэн санал хүсэлт уламжилж байлаа.

## **2.2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журмыг баримтлан зардлыг олгосон байна.**

Нийгмийн халамжийн тухай хуулийн 4.1-д “Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан болзол, шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамрагдах эрхтэй”, 18.8-д “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, 18.9-д “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг энэ хуулийн 18.8-д заасны дагуу нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу Монгол улсын Хүн ам хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 5 дугаар сарын 12-ны А/52 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх журам”, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын тушаалаар холбогдох шалгуур журмыг батласан байна.

Аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс ОНОТХҮ-ний чанарт тавигдах шалгуур болон холбогдох журмын дагуу баримтын бүрдлийг хангуулж төслийг санхүүжүүлсэн байна.

### **Дүгнэлт :**

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:**

1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хэвийн явагдаж байна.
2. Үйлчилгээ үзүүлэх эрх авсан ААН, ТББ-ын үйлчилгээний үр дүн чанарын шаардлага хангасан байна.
3. ОНОТХҮ-ний эх үүсвэрээс олгогдож байгаа хөрөнгө зарим төслийг хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй байна.
4. ОНОТХҮ-нд хамрагдвал зохих зорилтот бүлгийн суурь судалгааг нарийвчлан гаргаж хамрагдалтын түвшинг ахиулах, үйлчилгээний төрлийг олшруулах, зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

**Зөвлөмж: Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.Үүнд:**

### **Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга И.Оюунчимэгт**

1. Өрхийн үйлдвэрлэл явуулж буй иргэдэд олгож байгаа эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар дээд шатны байгууллагад уламжлах.

Холбогдох байгууллагын санал

  
**УВС АЙМАГ  
НИЙГМИЙН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТЭС**  
213400, Улангом, Увс аймаг  
Утас: 7045-3725  
Цахим хаяг: Uvs.Halamj.gov.mn

2016.07.29 № 166

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -тоот \_\_\_\_\_

УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус хэлтсийн 2014, 2015 онд халамжийн сангаас олгодог олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний олголт зарцуулалтын үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд дурьдсан зүйлүүдийг хүлээн зөвшөөрч өгөдсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж ажиллана.

ДАРГА -  И.ОЮУНЧИМЭГ



**Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар**

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний 2014, 2015 оны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналын хариу:

Холбогдох байгууллагаас гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй санал нэг байна гэсэн хариу ирүүлсэн тул тайлбар хийх шаардлагагүй болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  
АХЛАХ ШИНЖЭЭЧ  
АУДИТОР

ШИНЖЭЭЧ

С.АЛТАНХУНДАГА  
М.БАТСУУРЬ  
Т.НАМЖИЛ  
С.БАТСАЙХАН  
Л.БАТ-ОЧИР  
Я.ЗУНГАРАВ